



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Зээлийн гэрээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.11, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 02 дугаар тогтоол, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 9.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийг хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын хүрээнд үйлдвэрийн гаднах дэд бүтэц болох хүнд даачын автозам, төмөр замын салаа, үйлдвэрлэлийг цахилгаанаар хангах цахилгаан дамжуулах агаарын шугам, үйлдвэрийн талбай бэлтгэх, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зориулж хавсралтад заасны дагуу нийт 250,000,000,000.00 (хоёр зуун тавин тэрбум) хүртэлх төгрөгийн зээлийн гэрээг Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орж, үйл ажиллагаа эхэлсэн үеэс тооцож зээл, зээлийн хүүг төлөх нөхцөлтэйгээр Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулахыг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнноровт зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн барьцаанд Бүгд Найрамдах Энэтхэг улсын Инженерс Индия Лимитед компанийн боловсруулж буй нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэл, төслийн үр дүнд ирээдүйд бий болох хөрөнгийг тус тус барьцаалах талаар тус банктай хэлэлцээ хийхийг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ), "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнноров нарт даалгасугай.

3. "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн санхүүжилтийг Хөгжлийн банкаас тухай бүр авч үр ашигтай зарцуулах, гүйцэтгэсэн ажлын тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн ямаар хянуулан улирал бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулахыг гүйцэтгэх захирал Д.Цэрэнноровт үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001/...

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн  
09 дугаар тогтоолын хавсралт



"МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН  
БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЗАРДАЛ

Д/д	Зардлын төрөл	Нийт зардал (тэрбум төгрөг)
1	Үйл ажиллагааны зардал	13.80
2	Дэд бүтэц барих зардал	210.40
3	Зөвлөх үйлчилгээний зардал	10.80
4	Үйлдвэрийн талбай бэлтгэх зардал	7.80
5	Магадлашгүй ажлын зардал	7.20
	<b>Нийт дүн</b>	<b>250.00</b>